ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2020/124/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2020 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetsteg.e@audit.gov.mn
Аудитор: Б.Уранбилэг
Утас: 70503020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ**....................3
Аудитын тайлан....................5
2.1. Оршил....................5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага....................5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт....................5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин....................6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....................6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал....................6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар....................6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....................6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....................7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....................8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....................8
2.13. Шилэн дансны мэдээлэл....................8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт....................8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....................8
Менежментийн захидал....................9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан....................11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан....................11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....................12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан....................14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....................16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....................17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....................19

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.13 №1-6/57

танай______________-ны №_______________-т

АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ
У.ЭНХТҮВШИН ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг албаны дарга, хошууч У.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-аас 2020 оны 02 дугаар сарын 07–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/105 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино”

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Шүүхийн шинжилгээний албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 282419.9 мянган төгрөгөөс тооцон 2824.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6014.9 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын төлөвлөлтийн үе шатанд 1 хувиар тооцсоныг өөрчлөөгүй холбоотой болно. /шалтгааныг бичих/

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9618.0 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 2518.2 | 1583.0 | (935.1) |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 77288.7 | 72725.7 | (4562.9) |
| Үндсэн хөрөнгө | 645258.4 | 654876.4 | 9618.0 |
| **Нийт хөрөнгө** | 590625.2 | 559201.2 | (31423.9) |
| Өр төлбөр | 2164.4 | 1583.0 | (581.3) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 588460.8 | 557618.2 | (30842.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 590625.2 | 559201.2 | (31423.9) |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын дүнгээр авлага үүсгэн хэрэгжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тухайн жилийн хүнсний зарцуулалт тухайн жилийн онцлогоос шалтгаалан нэмэгдсэн байна. Харин бараа материалын дансны бэлэн бүтээгдэхүүн дансанд АИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажлын хүрээнд 2019 оны 22 дугаар тогтоолын дагуу 2000.0 мянган төгрөгийн үнэ бүхий ном худалдан авснаар, эм боох материалын дансанд эмнэлгийн зориулалтын хэрэгслийг аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй байсныг шилжүүлэн бүртгэснээр зэрэг шалтгаанаар үлдэгдэл өссөн байдалтай байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ШШГЕГ-аас нэгдсэн хангалтаар 5618.0 мянган төгрөгийн бичиг баримт уншигч тоног төхөөрөмж, аймгийн Засаг даргын 2019 оны А/474 дугаар захирамжаар өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 4000.0 сая төгрөгийн үнэ бүхий гал тогооны тоног төхөөрөмж шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны өглөг буурсан нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт төлөгдсөнөөр буурсан байна. Мөн 2018 оны албадах ажиллагааны төрийн сангийн данс андуурагдсан хүүхдийн тэтгэлгийн 282.2 мянган төгрөгийг төсөвт татагдсаныг 2019 онд буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Тайлант онд өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн актын үлдэгдлийг өглөг, авлагын үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 557618.2 мянган төгрөг болж 30.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тайлант онд улсын төсвөөс санхүүжих 553639.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 4686.3 төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 553639.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 553647.8 | 553639.0 | 8.7 | 99.9 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 4686.3 | 4686.3 | - | 100 |
| **Нийт дүн** | 558334.1 | 558325.3 | 8.7 | 99.9 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 558334.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 558334.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 558325.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь батлагдсан төсвийн төлөвлөсний дагуу зарцуулсантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** АИТХ-ын 2019 оны 22 дугаар тогтоолын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажлын хүрээнд 2000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлснээр соён гэгээрүүлэх зорилго бүхий ном худалдан авсан байна.

### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 453.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 453.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### 2.13. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 14 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага тогтоосноос 2 албан шаардлага бүрэн, 1 акт дутуу, 1 акт барагдаагүй байна. Үүнийг шийдвэрлүүлэх талаарх албан бичиг ирүүлсэн байна.

### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал:*

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

2019 онд бараа материал худалдан авах болон бэлтгэн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна. Энэ нь Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлээгүй байна.

*1.2. <u>Эрсдэл:</u>*

Худалдах авах, бэлтгэн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэхгүй байх нь тухайн бараа, ажил үйлчилгээ нь чанаргүй байх, гэрээний үүргийг хангалтгүй биелүүлэх, ашиг сонирхол үүсэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Худалдан авах ажиллагаатай холбоотой байгуулсан гэрээг гэрээний хугацаа дуусах, гүйцэтгэл гарсан тухай бүрт дүгнэж ажиллах.

*2. Зардлын холбоотой асуудал*

*<u>2.1. Илрүүлэлт:</u>*
Тээвэр шатахууны зардлаас 453.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна. Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

*2.2. Эрсдэл*:

Санхүүгийн тайлан алдаа тайлагнах, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

*2.3. Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, батлагдсан төсвийн хүрээнд эдийн засгийн ангиллаар зарцуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1 сарын 1 | 12 сарын 31 |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 79,806,869.03 | 74,308,736.85 |
| 33 | АВЛАГА | 2,518,212.49 | 1,583,016.91 |
| 33100 | Ажиллагчидтай холбоотой авлага | 2,236,062.49 | 1,583,016.91 |
| 33300 | Татаас,санхүүжилтийн авлага | 282,150.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 77,288,656.54 | 72,725,719.94 |
| 35100 | Түүхий эд материал | 25,944,021.40 | 27,245,197.40 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 24,994,109.40 | 25,622,809.40 |
| 35130 | Эм,боох материал | 949,912.00 | 1,622,388.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 0.00 | 1,325,280.00 |
| 35400 | Хангамжийн материал | 51,344,635.14 | 44,155,242.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 107,700.00 | 457,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,248,278.14 | 32,991,514.54 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 0.00 | 461,400.00 |
| 35440 | Түлш,шатах тослох материал | 3,000,000.00 | 385,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 17,988,657.00 | 9,859,628.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 510,818,286.47 | 484,892,506.38 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 510,818,286.47 | 484,892,506.38 |
| 392 | Биет хөрөнгө | 462,762,837.83 | 438,120,596.22 |
| 39201 | Барилга,байгууламж,орон сууц | 378,124,417.90 | 378,124,417.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 9,381,715.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 130,280,000.00 | 130,280,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 87,953,888.95 | 98,006,111.21 |
| 39205 | Машин,тоног төхөөрөмж (компьютер) | 58,095,947.20 | 66,277,947.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 36,427,323.56 | 45,626,386.48 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,070,540.00 | 21,506,540.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 6,384,678.76 | 11,681,919.39 |
| 39211 | Батлан хамгаалах,цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 3,657,824.00 | 3,657,824.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| 39215 | Хуримтладсан элэгдэл | 0.00 | 330,000.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 48,055,448.64 | 46,771,910.16 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 3,674,243.67 | 4,957,782.15 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 45,312,000.00 | 45,312,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 590,625,155.50 | 559,201,243.23 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,164,403.32 | 1,583,016.91 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,164,403.32 | 1,583,016.91 |
| 41300 | Өглөг | 2,164,403.32 | 1,583,016.91 |
| 41360 | Бусад өглөг | 2,164,403.32 | 1,583,016.91 |
| 41361 | Байгууллагад өгөх өглөг | 1,882,253.32 | 1,583,016.91 |
| 41362 | Хувь хүмүүст өгөх өглөг | 282,150.00 | 0.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН | 588,460,752.18 | 557,618,226.32 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 588,460,752.18 | 557,618,226.32 |
| 51101 | Засгийн газрын оруулсан капитал | 369,082,469.50 | 369,082,469.50 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 90,452,678.10 | 59,610,152.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 90,452,678.10 | 90,452,678.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -30,842,525.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 128,925,604.58 | 128,925,604.58 |
| VIII | НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 590,625,155.50 | 559,201,243.23 |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| № | Балансын зүйл | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 503,960,322.59 | 570,656,540.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,633,008.59 | 15,008,740.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,633,008.59 | 15,008,740.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,633,008.59 | 15,008,740.40 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 790,456.59 | 4,686,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,842,552.00 | 10,322,440.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 496,327,314.00 | 555,647,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 487,620,000.00 | 553,647,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 487,620,000.00 | 553,647,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,300,000.00 | 2,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,300,000.00 | 2,000,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 5,407,314.00 | 0.00 |
| 133003 | Хөрөнгийн | 5,407,314.00 | 0.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 500,766,385.80 | 601,499,066.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 500,766,385.80 | 601,499,066.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 489,175,920.87 | 600,125,511.44 |
| 21.0 | ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ | 349,865,662.49 | 412,584,903.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 342,562,962.22 | 404,071,103.77 |
| 210101 | Үндсэн цалин | 220,950,362.22 | 261,602,937.08 |
| 210102 | Нэмэгдэл | 118,612,600.00 | 131,396,166.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,000,000.00 | 10,572,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 500,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,302,700.27 | 8,513,799.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 573,400.54 | 203,948.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 19,162.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 23,952.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 4,790.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,729,299.73 | 8,261,944.92 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47,483,602.00 | 56,779,100.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,586,689.00 | 6,939,064.94 |
| 210302 | Түлш, халаалт | 34,407,519.00 | 39,662,305.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,489,394.00 | 10,177,730.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,515,594.00 | 33,705,744.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,045,000.00 | 3,574,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,484,179.00 | 17,395,747.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 3,687,054.00 | 5,815,715.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 384,000.00 | 137,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 915,361.00 | 5,662,632.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 0.00 | 1,120,250.00 |
| 2105 | Нормативт зардал | 27,115,743.00 | 41,864,050.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 570,260.00 | 722,506.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,545,483.00 | 41,141,544.90 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,329,425.00 | 12,074,765.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 405,000.00 | 1,664,250.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 0.00 | 160,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,924,425.00 | 10,250,515.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,733,800.00 | 2,345,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,733,800.00 | 2,345,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,990,614.00 | 4,101,467.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,349,470.00 | 2,578,414.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 528,500.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 401,084.00 | 472,397.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 104,000.00 | 136,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 554,500.00 | 892,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 53,060.00 | 22,656.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,141,480.38 | 36,669,880.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 830,160.00 | 566,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 559,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,311,320.38 | 35,543,780.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,590,464.93 | 1,373,554.82 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 36,000.00 | 364,800.00 |
| 213101 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 36,000.00 | 364,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,554,464.93 | 8,754.82 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,554,464.93 | 8,754.82 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 3,193,936.79 | -30,842,525.86 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 3,193,936.79 | -30,842,525.86 |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 491,987,046.00 | 560,616,250.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,067,046.00 | 4,686,300.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,067,046.00 | 4,686,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 784,896.00 | 4,686,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 784,896.00 | 4,686,300.00 |
| 120009 | Бусад орлого | 282,150.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 490,920,000.00 | 555,929,950.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 487,620,000.00 | 553,929,950.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 487,620,000.00 | 553,647,800.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 0.00 | 282,150.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,300,000.00 | 2,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,300,000.00 | 2,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 487,872,346.00 | 560,616,250.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 487,872,346.00 | 560,616,250.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 475,999,731.07 | 559,242,695.18 |
| 21.0 | ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ | 350,213,911.07 | 412,231,094.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 342,612,911.07 | 404,015,594.33 |
| 210101 | Үндсэн цалин | 221,000,311.07 | 261,602,937.08 |
| 210102 | Нэмэгдэл | 118,612,600.00 | 131,340,657.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,000,000.00 | 10,572,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 500,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,601,000.00 | 8,215,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,170,000.00 | 203,948.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 19,162.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 23,952.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 4,790.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,431,000.00 | 7,963,645.19 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47,483,602.00 | 56,779,100.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,179,523.00 | 6,939,064.94 |
| 210302 | Түлш, халаалт | 34,662,693.00 | 39,662,305.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,641,386.00 | 10,177,730.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,398,941.00 | 30,132,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,080,200.00 | 3,930,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,143,753.00 | 15,492,884.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 3,509,274.00 | 5,815,715.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 384,000.00 | 137,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,281,714.00 | 4,756,000.59 |
| 2105 | Нормативт зардал | 34,759,738.00 | 33,912,497.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 721,852.00 | 899,982.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,037,886.00 | 33,012,515.90 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,008,585.00 | 14,850,899.41 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 405,000.00 | 5,300,000.00 |
| 210602 | Тавилга | 3,300,000.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 0.00 | 160,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,303,585.00 | 9,390,899.41 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,733,800.00 | 2,345,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,733,800.00 | 2,345,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,501,154.00 | 4,108,053.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,860,010.00 | 2,585,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 528,500.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 401,084.00 | 472,397.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 104,000.00 | 136,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 554,500.00 | 892,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 53,060.00 | 22,656.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 900,000.00 | 4,883,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 900,000.00 | 4,383,450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,872,614.93 | 1,373,554.82 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 36,000.00 | 364,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 36,000.00 | 364,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,836,614.93 | 8,754.82 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,836,614.93 | 8,754.82 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 4,114,700.00 | 0.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 4,114,700.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,114,700.00 | 0.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,114,700.00 | 0.00 |
| 225102 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,114,700.00 | 0.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -4,114,700.00 | 0.00 |

### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | 308,128,902.00 | 27,841,400.00 | 87,258,741.31 | 423,229,043.31 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 60,953,567.50 | 0.00 | 0.00 | 60,953,567.50 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 101,084,204.58 | 0.00 | 101,084,204.58 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлангийн үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 3,193,936.79 | 3,193,936.79 |
| 2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл | 369,082,469.50 | 128,925,604.58 | 90,452,678.10 | 588,460,752.18 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлангийн үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -30,842,525.86 | -30,842,525.86 |
| 2019 оын 12 сарын 31-р үлдэгдэл | 369,082,469.50 | 128,925,604.58 | 59,610,152.24 | 557,618,226.32 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 558,334,100.0 | 558,325,345.2 | 8,754.8 | 100.0 |
| II | ИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 558,334,100.0 | 558,325,345.2 | 8,754.8 | 100.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 556,969,300.0 | 556,960,545.2 | 8,754.8 | 100.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 144,729,600.0 | 144,729,450.9 | 149.2 | 100.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл суутгал | 404,024,200.0 | 404,015,594.3 | 8,605.7 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 251,038,600.0 | 261,602,937.1 | -10,564,337.1 | 104.2 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 149,985,600.0 | 131,340,657.3 | 18,644,942.8 | 87.6 |
| 210103 | Унаа хоолны нэмэгдэл | 2,000,000.0 | 10,572,000.0 | -8,572,000.0 | 528.6 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.0 | 500,000.0 | 500,000.0 | 50.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 8,215,500.0 | 8,215,500.0 | 0.0 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.0 | 203,948.8 | -203,948.8 | 0.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.0 | 19,162.4 | -19,162.4 | 0.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.0 | 23,953.0 | -23,953.0 | 0.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.0 | 4,790.6 | -4,790.6 | 0.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,215,500.0 | 7,963,645.2 | 251,854.8 | 96.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,779,200.0 | 56,779,100.5 | 99.5 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,939,100.0 | 6,939,064.9 | 35.1 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 40,240,100.0 | 39,662,305.6 | 577,794.4 | 98.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,600,000.0 | 10,177,730.0 | -577,730.0 | 106.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,132,000.0 | 30,132,000.0 | 0.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,875,000.0 | 3,930,400.0 | -55,400.0 | 101.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,600,000.0 | 15,492,884.0 | 107,116.0 | 99.3 |
| 210403 | Шуудан,холбоо, интернетийн төлбөр | 6,228,000.0 | 5,815,715.4 | 412,284.6 | 93.4 |
| 210405 | Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 204,000.0 | 137,000.0 | 67,000.0 | 67.2 |
| 210406 | БҮТЭЗүйлс | 4,225,000.0 | 4,756,000.6 | -531,000.6 | 112.6 |
| 2105 | Нормативт зардал | 33,912,500.0 | 33,912,497.9 | 2.1 | 100.0 |
| 210501 | Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900,000.0 | 899,982.0 | 18.0 | 100.0 |
| 210502 | Хоол хүнс | 33,012,500.0 | 33,012,515.9 | -15.9 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,850,900.0 | 14,850,899.4 | 0.6 | 100.0 |
| 210601 | Багаж,техник хэрэгсэл | 5,300,000.0 | 5,300,000.0 | 0.0 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 160,000.0 | 160,000.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,390,900.0 | 9,390,899.4 | 0.6 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,345,600.0 | 2,345,600.0 | 0.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,345,600.0 | 2,345,600.0 | 0.0 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,108,100.0 | 4,108,053.0 | 47.0 | 100.0 |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,585,000.0 | 2,585,000.0 | 0.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 472,400.0 | 472,397.0 | 3.0 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 136,000.0 | 136,000.0 | 0.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 892,000.0 | 892,000.0 | 0.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 22,700.0 | 22,656.0 | 44.0 | 99.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,601,300.0 | 2,601,300.0 | 0.0 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,101,300.0 | 2,101,300.0 | 0.0 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.0 | 500,000.0 | 0.0 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,364,800.0 | 1,364,800.0 | 0.0 | 100.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 364,800.0 | 364,800.0 | 0.0 | 100.0 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 364,800.0 | 364,800.0 | 0.0 | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.0 | 1,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.0 | 1,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 558,334,100.0 | 558,325,345.2 | 8,754.8 | 100.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 4,686,300.0 | 4,686,300.0 | 0.0 | 100.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 553,647,800.0 | 553,639,045.2 | 8,754.8 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 553,647,800.0 | 553,639,045.2 | 8,754.8 | 100.0 |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |
| 131104 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 2,000,000.00 | -2,000,000.00 | 0.00 |